

Дундговь аймгийн Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны үйл ажиллагааны тайлан

2019-12-18

Рашаант

2019 онд ИТХ-н Тэргүүлэгчид, ажлын алба үйл ажиллагаандаа иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн асуудлыг хэлэлцэх, мэдээллээр хангах, төсвийн тодотгол хийж үр өгөөжийг дээшлүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр ажиллалаа.

Нэг.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан

Сумын ИТХ нь 2019 онд ээлжит 4 хуралдаан хийж 2019 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн тодотгол” 3 удаа, Сумын 2020 оны төсвийн төсөл”, “Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хагас бүтэн жилээр, 2020 оны үндсэн чиглэлийн төсөл”, “2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт 2 удаа оруулж, 2020 оны төлөвлөгөөний төсөл”, “Улсын тусгай хамгаалалтад газар авах тухай”, “Орон нутгийн тусгай хамгаалалтаас газар хасах тухай”, “Сумын тусгай хэрэгцээнд газар авах тухай”, Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ААН, Байгууллагад ИТХ-ын ажлын хороодоос хяналт, үнэлгээ хийх журам батлах тухай, “Нүүрс тээвэрлэлтийн хүнд даацын автомашины замаас бэлчээрт үзүүлж буй сөрөг нөлөө, авах арга хэмжээний тухай”, “Гурвансайхан”ХХК-ны ураны ашиглалтын лицензийн тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж зохих шийдвэрийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн хариуг БИНХуралд танилцуулсан.ИТХ-аас 28 заалт бүхий 17 тогтоол гаргасан байна. Тогтоолыг агуулгаар нь ангилж үзвэл Төсөв хөрөнгө баталсан,тодотгосон-3, ГЗБТөлөвлөгөөнд нэмэлт оруулсан-2, баталсан-1,Үндсэн чиглэл баталсан- 1, Тайланд үнэлэлт өгсөн-2 , газар тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авсан-2, Хураамж тогтоосон-2, Журам баталсан-1, хамгаалалтын бүс тогтоосон-1 тогтоолыг тус тус батлан гаргасан байна.



2. Тэргүүлэгчдийн хурал, шийдвэрлэсэн асуудлууд

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2019 онд 12 удаа хуралдаж 45 заалт бүхий 38 тогтоол гаргасан байна. Тогтоолыг агуулгаар нь ангилвал шагнал 7, Дотоод ажил 8, Хөрөнгө актлах, бүртгэх, дуудлага худалдаанд оруулах 6, төлөвлөгөө, Үндсэн чиглэл, төлөвлөгөө, хөтөлбөр батлах 3, СХС-тай холбоотой 1, хурлын тов тогтоох 6, ажлын хэсэг, зөвлөл байгуулах-6, төсөл дэмжих 1 тогтоол гаргасан байна.

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас уламжилсаны дагуу төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор 1 хүн, Алтангадас” одонгоор 2 хүн, “Хөдөлмөрийн хүндэт” медиалаар 2 хүн, “Алдарт эх” 2-р зэргийн одонгоор 9 эх шагнагдлаа.

2019 онд Тэргүүлэгчдийн хурлаар 60462900 төгрөгний эд хөрөнгийг бүртгэн авч, 4823040 төгрөгний эд хөрөнгийг акталсан байна.

2019 онд хийх ажлын төлөвлөгөөнд 15 асуудал төлөвлөснөөс 3 асуудал биелээгүй/Ажлын хорооны хяналт, Өмчийн хяналт, архивийн сургалт/ бөгөөд 80 хувийн биелэлттэй байна. ИТХ-ын ажлын албанаас 7 хоног бүр ажлаа төлөвлөж 7 хоногийн мэдээ, сарын шуурхай мэдээг гаргаж өгдөг. “БИНХ-ын даргын ажил дүгнэх журам”-ын дагуу БИНХ-ын дарга нарын ажлыг сар бүр дүгнэсний үндсэн дээр улирлаар урамшуулал олгож байна. Ажлын алба 4'844'894,1 төгрөгний эд хөрөнгө хариуцдаг бөгөөд эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтаа сайжруулж анхан шатны бүртгэлийг зааврын дагуу хөтлөн аудитийн шалгалтаар эд хөрөнгөтэй холбоотой зөрчил гараагүй.




Ахмадын баяр, Цагаан сараар байгууллагын харъяат 2 ахмадад хүндэтгэл үзүүлсэн. Ажлын албанд 27 албан бичиг ирж хариутай 10 бичгийн хариуг хугацаанд нь өгч 35 бичиг явуулсан байна. ИТХ-ын 21 төлөөлөгч, Засаг дарга, БЗД,Засаг даргын орлогч зэрэг 26 албан хаагчийн ХОМ-ийг 2018 оны байдлаар цахимаар гаргуулж нэгтгэн баталгаажуулж АТГ-т хүргүүлсэн..

Ажлын албанд 8 санал, хүсэлт ирсэнээс 8 хүсэлт барагдуулсан. Төрийн мэдээлэл, Нутгийн удирдлага, “Дундговийн амьдрал”сонинг эхний улиралд захиалж ажлын албаны хэрэгцээнд ашигласан.

Гурав. Сургалт, сурталчилгаа, зохион байгуулсан ажлын талаар

Монгол улсын хууль, аймаг, сумын ИТХ-аас гарсан тогтоол, шийдвэрийг БИНХ болон мэдээллийн цагаар иргэдэд яриа, таниулга хэлбэрээр 20 удаа хийж давхардсан тоогоор 1400 иргэн хамрагдсан.ИТХ, Тэргүүлэгчдээс гарсан шийдвэр, цаг үеийн ажлыг мэдээллийн самбараар ил тод тогтмол мэдээлж, **Хурал.mn** сайтын 4 үндсэн цэс , 28 дэд цэсд 40 мэдээ байршуулсан. Сайтын

хандалтын 25000-д хүрээд байна. “Асуувал хариулъя-4” номонд ИТХ, Тэргүүлэгч, ажлын албаны үйл ажиллагаанаас оруулж сурталчилсан.



Сумын ИТХ-аас баталсан “Шатар” хөтөлбөрийн хүрээнд сумын аварга шалгаруулах шатрын тэмцээн зохион байгуулж 10 иргэн оролцож эхний 3 байрыг шалгаруулж өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.



Шинэ үндсэн хууль батлагдасан тэмдэглэлт өдрөөр тусгай хөтөлбөр гарган хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгууллаа. Төрийн албаны тухай шинэ хуулиар “Дэвжээ” тэмцээн явуулж 5 баг оролцон эхний 3 байрыг өргөмжлөл , мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Арга хэмжээнд төрийн 5 байгууллага, иргэдийн төлөөлөл 60 орчим хүн оролцлоо.16 нас хүрсэн хүүхдүүд иргэний андгай өргөх ёслол боллоо.





Малчдын хүсэлтээр “Өлзийт сумын малын им, тамга” номыг шинэчлэн гаргаж, шинээр 67 өрх нэмэгдэж нийт 431 малчин өрхийн малын им тамгыг номонд оруулж 1 сая төгрөгөөр 400 ш ном хэвлүүлэн нийт малчин өрхөд хүргүүллээ. “Даацтай бэлчээр-амьдралын баталгаа” төслийн хүрээнд малчдыг бүлгээр хамтарч ажиллахын ач холбогдол, бэлчээр усны нөөцөө зүй зохистой ашиглах талаар тайлбарласан “Бэлчээр хамгаалахад малчдын оролцоо” номыг 800000 төгрөгөөр 400ш хэвлүүлэн малчдад хүргүүлсэн.



Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын баярын өдрийг тохиолдуулан хурлын ажлын албанаас сумын эмэгтэйчүүдийн дунд шатрын

аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж 12 эмэгтэй оролцож эхний 3 байрыг өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагналаа.




Сумын ЗДТГ-ын даргатай хамтран “Авлигагүй шударга нийгмийн төлөө хамтдаа” уриалгын нээлтийг соёлын төвд зохион байгуулж 5 төрийн байгууллагын дарга нартай уриалганд гарын үсэг зурж, уриалгыг нийтэд сурталчиллаа.



НҮБ, Швецарийн хөгжлийн агентлаг, Улсын Их Хурлын Тамгын газраас хамтран зарласан “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” тэтгэлэгт хөтөлбөрт “Чадавхтай хороо-Иргэний төлөөлөл” 3,5 сая төгрөгний төсөвтэй төсөл боловсруулж оролцон уг төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан. Төслийн хүрээнд дараахь ажлыг зохион байгууллаа.

“Уул уурхайн амьдралын мөчлөг” сэдэвт Мерит төслийн хүрээнд хийгдэж байгаа 2 өдрийн сургалтанд ИТХ-ын төлөөлөгчид, БИНХ-ын дарга нар зэрэг 10 хүн хамрагдаж сертификат гардан авлаа.



Ажлын хороодыг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг

“Чадвартай хороо-Иргэний төлөөлөл” тэтгэлэгт хөтөлбөрийг ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, ажлын хорооны дарга, Тэргүүлэгчдээс бүрдсэн 5 хүний бүрэлдхүүнтэй баг сургалт, хэлэлцүүлгийн төлөвлөгөө гарган ИТХ-ын даргаар батлуулж хэрэгжүүллээ. Сургалт хэлэлцүүлэгт сумын 18 хурлын төлөөлөгч, БИНХ-ын дарга 6, ахмадын хорооны төлөөлөл 3, иргэдийн төлөөлөл 3 хүн оролцож хурлын үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэдийн оролцоог хангаж, иргэдтэй төлөөлөгчид тогтмол харилцаатай байх талаар үнэтэй саналаа хэллээ. Сургалтаар “Хил хязгааргүй алхам”ТББ-ын Тэргүүн Н.Баярсайхан Сумын ИТХ-аас баталсан бодлогын баримт бичиг, суманд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд хяналт, үнэлгээ хийх арга зүйн талаар сургалт хийсэн.



Сургалтаар "Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд ИТХ-ын ажлын хороодоос хяналт үнэлгээ хийх журам"-ын төсөл

боловсруулж 2019 оны 10 сарын 11-ны өдөр ИТХ-ын ээлжит бус 10-р хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Уг журмын дагуу Ажлын хороодоос хяналт үнэлгээ хийх удирдамж гарган ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулж ажлын хороодын дарга нар, байгууллагуудын дарга нарт хүргүүлсэн. Төсөл хэрэгжиж байх хугацаанд ИТХ-ын дарга байгаль орчны улсын байцаагч, аймгийн цагдаагийн газартай хамтран байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж зөвшөөрөлгүй жонш олборлосон зөрчлийг таслан зогсоож хуулийн дагуу арга хэмжээ авхуулсан. Мөн хүнд даацын автомашины нүүрс тээвэрлэлтийн дагуу шалгалт хийлгэж тайланг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж Монгол улсын Ерөнхий сайдад нөхцөл байдлыг уламжилж арга хэмжээ авхуулахаар хүргүүлж хариуг иргэдэд сурталчилсан.

4. Хамтын ажиллагааны талаар

. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид УБ хотын Чингэлтэй Дүүргийн ИТХ-ын Ажлын албаны ажилтай танилцан туршлага солилцлоо. Уг арга хэмжээний хүрээнд тус дүүргийн нийслэлийн тэргүүний 3-р хорооны үйл ажиллагаатай танилцаж хүүхдийн номын өргөө, Чингэлтэйд үйлдвэрлэв дэлгүүрийг үзэж сонирхлоо.





Дорноговь аймгийн Хар айраг суманд болсон БИНХ-ыг чадавхжуулах сургалтанд урилгаар оролцож илтгэл тавьж харилцан туршлага судалсан.

Монголын нутгийн удирдлагын холбооны дэмжлэгтэйгээр Япон улсын парламентийн гишүүн Сайто Кений урилгаар Япон улсад ИТХ-ын Тэргүүлэгчид, н/б-ийн дарга нар туршлага судлах аялал хийсэн.



**“МОНГОЛЫН НУТГИЙН
УДИРДЛАГЫН ХОЛБОО”**

Улаанбаатар - 210648, Жигжидсүхийн гудамж - 3,
ЧД, 1-р хороо, Утас/факс: 976-11315638, 976-11-315637
E-mail: mala.yanjmaa@gmail.com, mala.sainbileg@gmail.com

2019.05.13 № 834/19
Танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН
ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ДАРГА Х.ОТГОНМӨНХ
ТАНАА

Монголын Нутгийн Удирдлагын Холбоо нь Монгол улс дахь нутгийн удирдлагын салбарыг хөгжүүлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг чадавхижуулах, Төрийн албан хаагчид, ИТХ-ын Төлөөлөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг билээ.

Танай сумаас удаа дараа тавьсан хүсэлтийг үндэслэн энэ удаа Япон улсын Парламентын гишүүн, Хөдөө аж ахуйн яамны сайд асан Сайто Кентэй уулзалт хийх, Парламентын ордны үйл ажиллагаатай танилцах, зарим хот, дүүргүүдийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, камержуулалт, гэрэлтүүлэг, иргэдийн оролцоо, сайн дурын бүлгүүдийн ажлын туршлагыг судалж суралцах албан ёсны айлчлалын арга хэмжээг 2019 оны 06 сарын 28-ны өдрөөс 07 дугаар сарын 03-ны өдрийн хооронд 5 шөнө, 6 өдрийн хугацаанд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Иймд өндөр хөгжилтэй орны сайн туршлага, ажлын арга барилаас суралцан, Монгол улсын хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг судлах зорилгоор уг айлчлалын бүрэлдэхүүнд танай сумаас наймаас илүүгүй төлөөлөгчдийг уг айлчлалд оруулах боломжтой гэдгийг Япон улсын холбогдох талуудтай харилцан тохиролцож уг шийдвэрийг гаргаад байна.

Уг айлчлалд оролцох нийт зардал нэг хүн тус бүр 3850.000 мянган төгрөг болох бөгөөд үүний 50 хувийг буюу нэг хүний 1.925.000/ нэг сая есөн зуун хорин таван мянган төгрөгийг манай байгууллага болон Япон улсын тал хариуцах боломжтой. Үлдсэн хүн тус бүр 1.925.000/ нэг сая есөн зуун хорин таван мянган төгрөгийг орон нутаг өөрсдөө харицана. Өөрөөр хэлбэл онгоцны билет болон зарим үзвэр үйлчилгээний мөнгийг танай байгууллага хариуцана.

Уг арга хэмжээнд оролцох шийдвэр болон оролцуулах бүрэлдэхүүний нэрсийг МНУХ-ны ажлын албанд зургаадугаар сарын 05-ны дотор өгнө үү?

ХҮНДЭТГЭСЭН,

МНУХ-НЫ ДЭД ТЭРГҮҮН

Г.МАНАЛЖАВ

招へい理由書

令和元年5月31日

在モンゴル日本国大使 殿

招へい人

省略

査証申請人

別紙 10名

上記の者の招へい目的等は次の通りです。

(1) 招へい目的

被招へい人10名は、MALA(モンゴル地方自治体協会)が
研修業務委託されているドンドゴビ県ウルジート郡の
郡議会議長および議員8名とMALAの職員2名です。

このたび、日本研修のため添付日程のように国会議事堂見学、
齋藤健衆議院議員訪問、練馬区区役所、清掃工場を訪問致します。
そして、私はその旅行の手配を担当しています。

(2) 招へい経緯

同上

(3) 申請人との関係

私は2009年に初めてモンゴルを訪問し、2010年から
ウランバートル国際マラソンの開始にあたり、日本での
広報を担当し、日本からの大会参加者の取りまとめを致して
おりました。その後、マラソンだけでなく日本からの
モンゴルへの観光客増大のため、日本の旅行業界へモンゴル
の観光資源や施設の紹介をしております。

そして、2017年からはMALAより委託を受け、MALAの日本
での活動の支援を致しております。

住所：横浜市保土ヶ谷区川島町1007番地

氏名：水町 陽一



Энэ жил ИТХ-ын хуралдааны танхимын тохижилтыг 809600 төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.



5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

ЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар мэдлэг олгох зорилгоор “ногоон гэрэл-цагаан шугам” тэмцээнийг зохион байгуулав.



Тус сумын 4-р багийн нутаг шарангад хэмээх газарт хууль бусаар хайлуур жонш олборлож байсан иргэдийг аймгийн МХГ болон цагдаагийн газрын ажлын хэсэгтэй хамтарсан удаа дараагийн хяналт шалгалтаар таслан зогсоож, байнгын пост ажиллуулан, буруутай этгээдүүдээр техникийн нөхөн сэргээлт хийлгэсэн.



Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн цагдаагийн газрын мөрдөн байцаах тасгийн ахлах, хошууч Б.лхагважав, онха-ны ажилтан хошууч Батцэцэг нарыг урьж 1 өдрийн сургалтыг нийт 60 иргэнд зохион байгуулсан.



Монгол цэргийн баяр арга хэмжээг зохион явуулж, 5 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулсан.


**МОНГОЛ ХУЛСАД ОРЧИН ЦАГИЙН ЗЭВСЭГТ ХҮЧИН
ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 98 ЖИЛИЙН ОЙ "МОНГОЛ
ЦЭРГИЙН БАЯР-2019" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР**

Үйл ажиллагааны зорилго:
Сумын залуучууд, өсвөр үеийг эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлэх,
ахмад үеэсээ суралцах, үлгэр дууримал авахад оршино.
Зохион байгуулагдах хугацаа, газар: 2019.3.16-18-ны өдрүүдэд Өлзийт сумын төвд

2019.3.16 ны өдөр
09.00: Шагайн харваа /Багийн харваа, хувийн цуваа/
13.00: Д.Ахагва-Очирын нэрэмжит сугалаа
15.00: Үндэсний бөхийн барилдаан /Зөвхөн Өлзийт суманд ажиллаж
амьдарч байгаа залуучуудын дунд/


2019.3.17-ны өдөр
09.00: Тар бөмбөгийн тэмцээн /18-с дээш насны эрчүүдийн дунд/
12.00: Дартсын тэмцээн /18-с дээш насны эрчүүдийн дунд/
13.00: Даалууны тэмцээн /40-с дээш насны эрчүүдийн дунд/

2019.3.18 ны өдөр
10.00: Үлэрийн дуулал, төрийн далбаа залах ёслол, Баярын хурлын нээлт
10.10: Хүндэт зочдыг хүндэтгэлийн сурдалд урьж танилцуулах
Зөвлөгөөн нээж Үлэргүүлэгчдээс үг хэлэх
Сумын эрэгтэйчүүдийн зөвлөлийн 2018 оны товч тайлан
Сумын Засаг даргын мэндчилгээ
Хүндэт зочдын мэндчилгээ
10.30: Шагнал гардуулах ёслолын ажиллагаа
11.00: Дотоод зохион байгуулалтын асуудал
18.00: Үлэв оройн тоо
19.30: Хүндэтгэлийн концерт, үдшийн цэнгүүн

**Өлзийт сумын
Эрэгтэйчүүдийн зөвлөл**



ЕБС-ийн нийгмийн ажилтны зүгээс охидыг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөөгийн багуудын 50 ээжид “охинтой ээж” сэдэвт захидал бичиж 2019 оны 4-р сард хүргүүлсэн.



ОНХС-ийн 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр Ебс-ийн спорт заалны орчныг камержуулан нийт 8 камер, тоног төхөөрөмжийг суурилуулсан.



Сумын ГХУСАСЗөвлөлөөс цагдаагийн хэсгийн тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр цагдаагийн маяк дуут дохиолол чанга яригчаар хангалаа.



Гэмт хэргийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	2018	2019
1.	Хүчин	1	1
2.	Мал хулгай	1	1
3.	Хүний эрүүл мэндэд халдах	4	3
4.	Бусад		1

Зарцуулсан төсөв, хөрөнгө

№	Хэрэгжүүлсэн үйл ажилагаа	Хэрэгжүүлсэн хугацаа	Мөнгөн дүн ₮	Эх үүсвэр
1	“Малын им, тамганы жагсаалт” гарын авлага	2019 он 03-р сард	900.000	Малчидаас
2	Монгол цэргийн баярт зориулсан үйл ажиллагаа	2019 он 03-р сард	2.250.000	Нутгийн зөвлөл, ААНБ-ын хандив, тусламж

3	Эргүүл шалгалтын шатахуун	2019 оны 1-р улиралд	545.000	Сумын ИТХ, ЗДТГ
4	Бичиг хэргийн зардалд	1-р улиралд	30.000	ИТХ, ЗДТГ-аас
5	Спорт заалны камержуулалт	2-р улиралд	3.000.000	Сумын ОНХСан
6	Эргүүл, Хяналт, шалгалтын шатахуун	3-р улиралд	492.500	Сумын ИТХ, ЗДТГ
7	Цагдаагийн маяк, чанга яригч	2019 оны 10-р сард	200.000	Сумын ИТХ
8	Сургалтын зардалд	2019 оны 9-р сард	118.800	Сумын ЗДТГ

Нийт: 7.536.300 төгрөг

6. Улаан загалмайн ажлын талаар

2019 оны 10-р сарын 18-нд Дундговь аймгийн Улаан загалмайн хорооноос зохион байгуулсан “МУЗН-ийн ивээн тэтгэгч гишүүдийн 5-р чуулган”-д 10 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. 2019 онд ивээн тэтгэгч онцгой гишүүнээр нийт 16 иргэн шинээр элсэж, сумын хэмжээнд нийт 36 онцгой гишүүнтэй болж бусдын сайн сайхны төлөө нэгдэж буй энэрэнгүй үйлстний тоо өсөн нэмэгдэж байна. Үүнээс 1-р багийн малчин Батжаргал ивээн тэтгэгч мөнгөн гишүүн болсон байна. Гурвансайхан суманд зохион байгуулагдсан Ивээн тэтгэгч онцгой гишүүдийн чуулганд оролцогчдоос 5-р багийн малчин, ивээн тэтгэгч онцгой гишүүн Д.Цэцэгбаяр, 4-р багийн малчин ивээн тэтгэгч онцгой гишүүн Ц.Долгормаа нар “Нигүүлсэл” мөнгөн медалиар, 1-р багийн малчин, ивээн тэтгэгч онцгой гишүүн Г.Алтанцэцэг “Нигүүлсэл” алтан медалиар тус тус шагнагдсан байна. 2020 онд энгийн болон онцгой гишүүдийн тоог нэмэгдүүлж, ивээн тэтгэгч онцгой гишүүдийн 6-р чуулганыг сумандаа зохион байгуулж, МУЗН-ийн үйл ажиллагааг түгээн сурталчлах зорилго тавиад байна.

Татвар төвлөрүүлэлтийн хувьд: 2018 оны эцсээр сумын АШХ-оос МУЗН-ийн татварт 2'150'000 төгрөгийн татвар төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 1'408'000

татвар төвлөрүүлсэн байна. 2019 онд урьдчилсан байдлаар 550,000 төгрөгийн татвар төвлөрүүлсэн байна.

Тайлан бичсэн:

Ж.Наранжав

